

# ТОЙМ

---



**ОЛОН УЛСЫН  
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.08.05

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын ажилгүйдлийн түвшин 4.1%-иас 4.3% болж өссөн байна
- Уоррен Баффетийн Berkshire Hathaway компани Apple-ын хувьцааныхаа талыг заржээ
- “Goldman Sachs” дотоодын валютаас илүү ам.доллараар нэрлэгдсэн бондыг илүүд үзэх нь зүйтэй гэж хөгжиж буй орнуудын хөрөнгө Оруулагчдад зөвлөлөө
- Nasdaq залруулгын бүсэд (Correction territory) орлоо
- БНХАУ-ын үйлдвэлэлийн салбарын индекс (PMI) 6-р сард 49.5 байсан бол 7-р сард 49.4 болж буурсан байна
- CME FedWatch Tool-ийн мэдээлснээр, Холбооны Нөөцийн Сангийн есдүгээр сард хүүгээ 50 суурь нэгжээр бууруулах магадлал 73.5%-д хүрээд байна

2024 он 8-р сарын 5

Dow Jones	39,737.26
S&P 500	5,346.56
Nasdaq	16,776.16
DAX	17,661.22
FTSE 100	8,174.71
S&P/ASX 200	7,943.2
HANG SENG	16,945.51

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	-1.51%	-1.98%	0.92%	5.43%	13.32%	12.86%
S&P 500	-1.84%	-2.14%	-3.96%	12.09%	19.40%	20.51%
Nasdaq	-2.43%	-3.42%	-8.59%	11.76%	20.76%	13.08%

2024 оны 8 сарын 5-ний 11:00



Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	-2.33%	-3.60%	-4.41%	5.43%	10.72%	12.05%
FTSE 100	-1.31%	-1.42%	-0.36%	5.71%	8.07%	14.77%

2024 оны 8 сарын 5-ний 11:00



Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	-2.80%	-3.32%	-1.25%	1.76%	5.45%	2.47%
Hang Seng	-0.90%	-2.64%	-5.71%	-1.55%	-14.10%	-35.89%

2024 оны 8 сарын 5-ний 11:00





## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### АНУ-ын зах зээлийн уналтын суурь шалтгаан

Хувийн хэвшлийн ажлын байрны өсөлт удааширч, ажилгүйдлийн түвшин 4.1%-иас 4.3% болж өссөн байна. Мөн үйлдвэрлэлийн салбарын эдийн засгийн эрүүл мэндийг хэмжихэд ашиглагддаг чухал үзүүлэлт болох (ISM) үйлдвэрлэлийн индекс долдугаар сард 50-с бага гарсан ба 46.6 болж буурсан байна. Түүнчлэн Tesla, Microsoft, Amazon зэрэг зарим компаниудын ирэх улирлын орлогын төсөөлөл буурсан байна. Ийнхүү хөрөнгө оруулагчид улирлын орлогын тайлан болон эдийн засгийн чухал мэдээнүүдэд хариу үйлдэл үзүүлснээр гол жишиг үзүүлэлтүүд буурч хаагджээ.

### Хиймэл оюун ухааны хөгжүүлэлтийн зардал нэмэгдэнэ

S&P 500-ийн зах зээлийн үнэлгээний бараг 40%-ийг төлөөлдөг компаниуд, үүнд Microsoft, Meta Platforms (Facebook), Apple, Amazon.com зэрэг багтана, 2-р улирлын ашиг орлогоо мэдээлсэн байна. Үр дүн нь хүлээгдэж байснаас ялгаатай байсан ч хиймэл оюун ухааны (AI) чадавхийг бий болгохын тулд их хэмжээний хөрөнгө зарцуулна гэж нийтээрээ мэдэгджээ.

Amazon.com-ын хувьцааны үнэ баасан гарагийн арилжаагаар тайлан болон ашгийн мэдээний дараа 11%-иар унасан нь тус компани оны эхний хагаст 30 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалтын зардал гаргасантай холбоотой байна. Энэ хөрөнгө оруулалтын тал хувь нь үүлэн тооцооллын хэлтэс болох AWS-ийн хиймэл оюун ухааны шаардлагыг дэмжих зорилготой байжээ. Майкрософт 2-р улиралд AI хөгжүүлэлтэд 19 тэрбум ам.доллар зарцуулсан бол Meta энэ оны хоёрдугаар хагаст ойролцоогоор 37-40 тэрбум ам.доллар зарцуулна гэж тооцоолжээ. Alphabet мөн энэ хугацаанд ойролцоогоор 24 тэрбум ам.доллар зарцуулна гэж тооцоолж байна.

### Хүүг бууруулах хүлээлт өсөхийн хэрээр өгөөж буурав

ISM-ийн тайлан болон ажлын байрны мэдээлэл гарсны дараа урт хугацааны хүүгийн түвшин буурч, 10 жилийн хугацаатай ЗГҮЦ өгөөж 3.79%-д хүрчээ. Холбооны нөөцийн сан богино хугацааны хүүгийн хэмжээг хэвээр үлдээсэн ч цаашид хүү бууруулах хүлээлт нэмэгдсэн байна.

### График 1: АНУ-ын NASDAQ индексийн ханшийн таамаглал







## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Хятадын хөрөнгийн биржүүдийн холимог байдал

Хятадын үйлдвэрлэлийн сул мэдээллээс үүдэн хөрөнгө оруулагчдын сэтгэл санаа буурсан нь Хятадын хөрөнгийн биржүүдэд холимог үр дүн авчирлаа. Shanghai Composite индекс 0.5%-иар өссөн бол CSI 300 blue chip 0.73%-иар буурчээ. Харин Хонг Конгод Hang Seng индекс 0.45%-иар буурсан байна.

### Үйлдвэрлэл уналттай хэвээр байна

Үндэсний статистикийн товчооны мэдээлснээр, үйлдвэрлэлийн салбарын Худалдан авалтын менежерүүдийн албан ёсны индекс (PMI) 6-р сард 49.5 байсан бол 7-р сард 49.4 болж буурсан байна. Үйлдвэрлэл болон шинэ захиалга буурсантай холбоотойгоор энэ үзүүлэлт сар бүр буурч байгаа нь үйлдвэрлэлийн эрч сул байгааг харуулж байна. Энэхүү үзүүлэлт нь сэргэлтийн утгыг илэрхийлэх 50-ын босгоос доогуур хэвээр байна.

### Үйлчилгээний салбарын PMI

Барилга болон үйлчилгээний салбарын үйл ажиллагааг хэмждэг үйлдвэрлэлийн бус салбарын PMI индекс 6-р сард 50.5 байсан бол 7-р сард 50.2 болж буурчээ. Албаныхан энэ уналтыг Хятадын зарим хотуудад улирлын чанартай хүчин зүйл болон цаг агаарын эрс тэс уур амьсгалтай холбон тайлбарласан байна.

### Аж үйлдвэрийн ашиг өсөж байна

Албан ёсны мэдээллээр, аж үйлдвэрийн пүүсүүдийн ашиг 2024 оны зургадугаар сард 3.6%-иар өссөн нь тавдугаар сард 0.7%-иар өссөн үзүүлэлттэй харьцуулахад өсөлт хурдассан байна. Шинжээчдийн үзэж байгаагаар аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн өсөлт эрчимжиж, үйлдвэрлэгчийн үнийн бууралт удаашралтай байгаа энэ үед үндсэн орлого тогтвортой сэргэж байгаа нь зургадугаар сарын өсөлтөд нөлөөлсөн гэж үзэж байна.

### Дотоодын эрэлт сул байгаагаас үүдэлтэй бээжингийн арга хэмжээ

Гэсэн хэдий ч дотоодын эрэлт тасралтгүй сул байсаар байгаа нь сүүлийн үеийн эдийн засгийг эрчимжүүлэх арга хэмжээнүүд хэрэглээг нэмэгдүүлэхэд төдийлөн нөлөө үзүүлээгүй тул Бээжин эдийн засгаа дэмжих арга хэмжээгээ үргэлжлүүлнэ гэсэн таамаглалыг төрүүлж байна.

### График 2: Hang-Seng индексийн ханшийн таамаг



# ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning July 29, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
 MCD	 TLRY	 SOFI	 AMD	 BA	 META	 MRNA	 AMZN	 XOM	
 ON	 SPR	 PYPL	 MSFT	 NCLH	 ARM	 CNQ	 AAPL	 CVX	
 PHIL	 SYM	 PFE	 SBUX	 KHC	 QCOM	 CROX	 INTC	 SNDL	
 BANC	 F5	 BP	 ARST	 MO	 CVNA	 COP	 COIN	 BRO	
 LTC	 ESI	 PG	 PINS	 WDC	 LRCX	 MBLY	 DKNG	 FRNT	
 CNA	 RMBUS	 LEID	 FSLR	 CAMC	 WDC	 W	 ROKU	 MAG	
 OIS	 SBA	 MRK	 CZR	 GEN	 IOT	 SIRI	 BLOK	 TWST	
 PROV	 BYON	 COR	 EA	 HUM	 PAYC	 TM	 MAR	 ENB	
 HOPE	 JB	 GEN		 TEVA	 ALB	 GOOS	 SNAP	 FLU	
 CIV	 CORP			 MA	 AG	 F&N	 MELI	 PAA	

## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning August 05, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
 BRK.B	 PLTR	 UBER	 SMC	 SHOP	 HOOD	 LILLY	 SOUN	 CGC	
 CG	 HIMS	 CELH	 RIVN	 DIS	 MGNI	 VST	 ELF	 NKL	
 KRYS	 CLOV	 FUBO	 ABNB	 NVO	 APP	 PLUG	 UNITY	 ERJ	
 FIBP	 LCID	 CAT	 UFUN	 CVS	 DGT	 DDOG	 PARA	 NFE	
 ALPH	 R	 BAX	 DEV	 GPN	 SARE	 CHEN	 TTD	 CFC	
 TSN	 CAR	 VMC	 RDDT	 EMR	 HUBS	 NVAX	 EFCR	 BRY	
 AXSM	 TDC	 ATI	 GIGI	 AUR	 OXY	 CRON	 CLSK	 LEGN	
 BIOX	 CSX	 CEG	 AXON	 LYFT	 ET	 CYBK	 ARRY	 EMBC	
 BNTX	 Z	 CLR	 UPST	 SONY	 CM	 HIMX	 GGO	 AMCN	
 GSL	 SIMN	 M	 AMGN	 DT	 DUTB	 MIR	 BIO	 ALQ	